



**УЛААНБААТАР ЛИФТ НӨҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 12 сарын 10 өдөр

Дугаар A/28

Улаанбаатар хот

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 214 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх ажлыг байгууллагын хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	М.Энхбат	Ерөнхий инженер
Гишүүд:	Ц.Өсөхжаргал Ц.Уранбилэг	Хүний нөөцийн мэргэжилтэн Хяналтын инженер
Нарийн бичиг:	Н.Нарангуа	Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх, дараах арга хэмжээг авч ажиллахыг Ажлын хэсэг (М.Энхбат)-т үүрэг болгосугай:

2.1. иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлыг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд судалж, шуурхай, хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэж, хариу өгөх;

2.2. иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хүнд суртал гаргасан, удаасан, шийдвэрлээгүй, хууль бус шаардлага тавьсан, зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцож ажиллах;

2.3. иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэлх хугацаанд тухайн өдрийн 16:00 цагаар тасалбар болгон батлагдсан маягтын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (З.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ГАН-ЭРДЭНЭ